**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2020 оны 10 сарын 16 өдөр Дугаар А/485 Чингис хот

Коронавирусын гамшгийн эрсдэлийн
үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын үндсэн чиглэл, Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөө, Шадар сайдын 2017 оны А/08 дугаар тушаалаар батлагдсан эрсдэлийн үнэлгээний аргачлалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн хэмжээнд шинэ коронавируст халдварын эрсдэлийг үнэлэх, дэгдэлт үүссэн тохиолдолд аж ахуй нэгж, байгууллага бүр халдварыг даван туулах чадавхийн үнэлгээг хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн дарга | Д.Баасандорж | Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| Нарийн бичиг: | Т.Мөнхчимэг | Онцгой байдлын газрын гамшгийн эрсдэлийн үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, дэслэгч |
| Гишүүд: | Г.Ганцэцэг | Зооноз өвчин судлалын төвийн тархвар Судлаач |
| | К.Кульжан | Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга |
| | Б.Энхболор | Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч |
| | Д.Амаржаргал | Цагдаагийн газрын нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга |
| | Б.Бат-Эрдэнэ | Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, ахлах дэслэгч |
| | О.Эрдэнэболд | Боловсрол, соёл урлагийн газрын Биеийн тамир, эрүүл мэндийн боловсрол хариуцсан мэргэжилтэн |

231010807

| | |
|---|---|
| Б.Хэрлэнцэцэг | Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн уур амьсгалын технологийн инженер |
| Н.Оюунмандал | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн |
| Н.Алтангэрэл | Тагнуулын газрын хэлтсийн дарга Дэд хурандаа |
| Г.Гантөмөр | Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал аж ахуйн үйл ажиллагааны дарга |
| С.Наранхүү | Авто тээврийн төвийн Улсын хяналтын байцаагч |

2. Гамшгийн эрсдэлийн үнэлгээг 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн дотор багтаан хийж дуусгахыг ажлын хэсэгт даалгасугай.

3. Гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнг аймгийн онцгой комисст танилцуулж, удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Баасандорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ИДЭРБАТ